

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон Санхүүгийн тайланд
өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон ЛэндМН ББСБ ХК-ийн 2018 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар “Хангалттай” гэж дүгнэсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



..... /О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг чөлөөлөх, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Д.Бат-Очирын хүсэлтээр түүний бүрэн эрхийг 2018 оны 10 дугаар сарын 24-ны өдрөөр тасалбар болгон, хараат бус гишүүн Б.Гантулгын хүсэлтээр түүний бүрэн эрхийг 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор дуусгавар болгосныг баталгаажуулсугай.
2. Компанийн дүрэмд заасан 1 жилийн бүрэн эрхийн хугацаа дуусч байгаатай холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дор дурдсан гишүүдийг сонгуульт үүргээс чөлөөлсүгэй.

2.1. ТУЗ-ийн ердийн гишүүн:

- 2.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэнгийн Болдбаатар
- 2.1.2. Монгол Улсын иргэн Баянжаргалын Дэлгэржаргал
- 2.1.3. Монгол Улсын иргэн Володьягийн Баярсайхан
- 2.1.4. Монгол Улсын иргэн Нармандахын Цэвэгмид
- 2.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээгийн Энх-Амгалан
- 2.1.6. Их Британи улсын иргэн Мэтью Вэлч

2.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн:

- 2.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүүгийн Боргил
- 2.2.2. Монгол Улсын иргэн Жигдэнгийн Жаргалсүрэн
- 2.2.3. Монгол Улсын иргэн Чинбатын Номин

3. Санал хураалтын дүнг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар сонгосугай.

3.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

- 3.1.1. Монгол Улсын иргэн Очирсүрэнгийн Болдбаатар
- 3.1.2. Монгол Улсын иргэн Баянжаргалын Дэлгэржаргал
- 3.1.3. Монгол Улсын иргэн Володьягийн Баярсайхан
- 3.1.4. Монгол Улсын иргэн Нармандахын Цэвэгмид
- 3.1.5. Монгол Улсын иргэн Сэнгээгийн Энх-Амгалан
- 3.1.6. Их Британи улсын иргэн Мэтью Вэлч

3.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

- 3.2.1. Монгол Улсын иргэн Сүрэнхүүгийн Боргил

3.2.2. Монгол Улсын иргэн Жигдэнгийн Жаргалсүрэн

3.2.3. Монгол Улсын иргэн Чинбатын Номин

4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шинэ бүрэлдэхүүний талаар Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид мэдэгдэж, олон нийтэд мэдээлэхийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА



..... /О.БОЛДБААТАР/

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13, 62.1.15 дахь заалт, 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “компани”)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны цалин, урамшууллыг энэхүү тогтоолын Хавсралт 1-д заасны дагуу баталсугай.
2. Цалин, урамшууллын зардалд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргад даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

...../О.БОЛДБААТАР/



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
2019 ОНЫ ТӨСВИЙН САНАЛ

	Нэг хүний /1 удаа/	Жилийн зардал
Цалин үндсэн (Жилд 5 удаа)-ТУЗ-ийн дарга	800,000	4,000,000
Цалин үндсэн (Жилд 5 удаа)-ТУЗ-ийн гишүүн	500,000	22,500,000
Хорооны даргын нэмэгдэл (Улирлын)-3 хороо	100,000	1,500,000
Бичиг хэргийн зардал	50,000	250,000
ТУЗ-ийн хурлын зардал (Жилд 5 удаа)	200,000	1,000,000
Уулзалт, тусгай арга хэмжээ, бусад	1,000,000	5,000,000
НИЙТ ТӨСӨВ		34,250,000

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**


1. Компанийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын нэгдүгээр Хавсралтаар баталсугай.
2. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, дүрмийн хувийг Санхүүгийн Зохицуулах хороонд хүргүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
3. Дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл, Гүйцэтгэх удирдлага (Б.Гантулга)-д тус тус үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



/О.БОЛДБААТАР/

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ
ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
04 ДҮГЭЭР ТОГТООЛЫН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ**



Дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд /цаашид “Дүрэм” гэх/ оруулж байна. Үүнд:

1. Дүрмийн 2.2 дах заалтын “Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Үндсэн хуулийн гудамж, Нью Майнд Групп ХХК-ийн байр” гэснийг **“Компанийн төв байр дараах хаягт оршин байрлана: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34 хаягт байрлах Сувд төв, 1 болон 2 тоот”** гэж өөрчлөх;
2. Дүрмийн 4.2 дах заалтын “Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд: 4.2.1.Зээлийн үйл ажиллагаа; 4.2.2.Төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулинд заасан бусад төрлийн үйл ажиллагаа; 4.2.3.Хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа” гэснийг **“ Компани нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна. Үүнд: 4.2.1. Зээл; 4.2.2. Факторингийн үйлчилгээ; 4.2.3. Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ; 4.2.4. Гадаад валютын арилжаа; 4.2.5. Итгэлцлийн үйлчилгээ; 4.2.6. Төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулинд заасан бусад төрлийн үйл ажиллагаа; 4.2.7. Хуулиар хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа”** гэж тус тус өөрчлөх.
3. Дүрмийн 9.6.22 дах заалтад “Компани нь энэхүү дүрмийн 4.2.6 дах заалтад заасан Санхүүгийн Зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн дагуу эрхлэх Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх эсэх асуудлыг бие даан шийдвэрлэх” гэж нэмэх. Үүнтэй холбоотойгоор Дүрмийн одоогийн 9.6.22 дахь заалтын дугаарыг **“9.6.23”** болгож өөрчлөх.

**“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТОГТООЛ**

2019 оны 3 дугаар сарын 23-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа халааслах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 дах хэсэг, 62.1.15, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.14, 9.6.15 дах заалт, 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн гүйцэтгэх удирдлагын болон ажиллагчдын дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5 (тэг бүхэл аравны тав) хувь буюу 4,000,000 (дөрвөн сая) ширхэг энгийн хувьцааг халааслах буюу эргүүлэн худалдаж авахаар шийдвэрлэж, Төлөөлөн Удирдах Зөвлөлд зөвшөөрсүгэй.
2. Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх нөхцөл, журмыг тодорхойлж, энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



..... /О.БОЛДБААТАР/